БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТЖАРГАЛ

2021 оны 3 дугаар сарын 1-ны өдөр

# “ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021.01.28 Сайншанд сум

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Төсөв /сая төг/ | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог идэвхжүүлэх, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.** | | | | | | |
| 1 | Судалгаа, шинжилгээ, төлөвлөлтөд суурилсан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | Улирал бүр | - | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Аймгийн Цагдаагийн газар | Судалгаанд суурилсан төлөвлөлт хийгдсэн байна. |
| 2 | Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд тусгай чиг үүрэгтэй төрийн байгууллагын хамтарсан үзлэг шалгалтыг тогтмол явуулж | Хагас бүтэн жилд | 1.0 | Аймгийн Мэргэжлийн хяналтын газар | Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар | Хяналт шалгалт хийгдсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | илэрсэн зөрчил бүрт хариуцлага тооцох | | | | | |
| 3 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэр дээр хариуцсан хууль сахиулах болон бусад байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж хамтран ажиллах | Жилдээ | - | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | Мэдээллээр хангагдсан байна. |
| **Зорилт 2:Гэмт хэрэг зөрчилд өртөж хохирсон болон гэмт хэрэг зөрчил үйлдсэн иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах.** | | | | | | |
| 4 | Хохирогчийг хууль зүйн зөвлөгөөгөөр хангах, төлбөрийн чадваргүй яллагдагч, шүүгдэгч нарт эрх зүйн туслалцаа үзүүлэх | Сар бүр | - | Хууль зүйн туслалцааны төв | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Өмгөөлүүлэх эрх хангагдсан байна. |
| 5 | Сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах | Жилдээ | 1.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | Сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилээ үзүүлдэг ТББ чадавхижсан байна. |
| 6 | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ард иргэдийн дунд нөлөөллийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх | Улирал бүр | 1.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | Мэдээллээр хангагдсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт3: Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 7 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ахлах ангийн сурагчдад цахим болон тэнхимийн сургалт, уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах | Улирал бүр | 2.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд,<br><br>Боловсрол, соёл урлагийн газар | Энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна. |
| 8 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэр дундаа хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зурагт хуудас шторк бэлтгэж цахим орчинд байршуулах. | Жилдээ | 2.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | |
| 9 | Сумдад багийн нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулж, малчид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ажилгүй болон эмзэг бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулах | Улирал бүр | 2.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | |
| **Зорилт 4: Иргэдийн амьдрах аюулгүй орчинг бүрдүүлэх** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | Иргэд оршин суугчийн аюулгүй байдлын орчны эрсдэлийн үнэлгээ судалгаа хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Улирал бүр | - | Аймгийн Цагдаагийн газар | Сумдын Засаг дарга нар<br>СӨХ | Иргэдийн амьдрах аюулгүй орчин бүрдсэн байна. |
| 11 | Дэлгүүр болон үйлчилгээний бусад газруудын гадна гэрэлтүүлгийг сайжруулах, стандартын шаардлага хангасан камер байрлуулах | Жилдээ | - | Аймгийн Цагдаагийн газар | Сумдын Засаг дарга нар<br>СӨХ<br>ТББ | |
| 12 | Аж ахуй нэгж байгууллага иргэдийн оршин суух газрын хяналтын камержуулалтыг нэмэгдүүлэх | Жилдээ | - | | | |
| **Зорилт 5:Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, хор хохирлыг иргэд олон нийтэд таниулах** | | | | | | |
| 13 | Орон нутгийн телевиз болон цахим мэдээллийн хэрэгслээр үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон түмэнд таниулах, хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг шинэлэг хэлбэрээр тодорхой давтамжтай явуулах. | Жилдээ | 1.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд | Иргэдийн эрх зүйг боловсрол дээшилж, байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал, гарын авлага хийж иргэдэд тараах, олон нийтийн газарт байршуулах | Улирал бүр | 1.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд,<br><br>ТББ | |
| 15 | Соёл, урлагийн байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | Улирал бүр | 2.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд<br><br>Боловсрол, соёл урлагийн газар<br><br>ТББ | |
| 16 | Үүрэн холбооны байгууллагуудын үүргийг нэмэгдүүлэх | Сар бүр | 1.0 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ | Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд<br><br>Үүрэн холбооны байгууллагууд | |

---oOo---